

# БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЛБАРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН 2020 ОНЫ ТАЙЛАН

2020 оны 12-р сарын 31-ний өдөр

## 1. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТ

### ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

- Суралцагчдад ээлтэй сургалтын орчныг бүрдүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх, тусгай хэрэгцээт хүүхдийг ердийн сургууль, цэцэрлэгт сурах, хөгжих боломжийг нэмэгдүүлэх зорилгоор дараах бүтээн байгуулалтыг хийнэ.

- 273 цэцэрлэг ашиглалтад оруулах; / жил бүр 70 цэцэрлэг /
- 200 шинэ сургууль ашиглалтад оруулах; / жил бүр 50 сургууль /
- Тусгай хэрэгцээт сургууль, цэцэрлэгийн барилгыг шинэчилж, өргөтгөх; / жил бүр 2 сургууль, цэцэрлэг /
- Жил бүр 100-аас доошгүй нүхэн жорлонтой цэцэрлэг, сургууль, дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн өрөөтэй болгох;

- Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулийн урлаг, биеийн тамирын хичээлийн агуулга, хөтөлбөрийг сайжруулж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр бүрэн хангана.

- Шинжлэх ухаан, технологи, инновацын чиглэлээр шинжлэх ухааны парк, хүрээлэнгийн цогцолбор, уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн барилгын ажлыг эхлүүлж, олон улсын стандартад нийцүүлнэ.

- Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн орон нутаг дахь их сургуулиудыг хотхон хэлбэрт үе шаттай шилжүүлнэ.

Монгол Улсын 2020 оны төсөвт Боловсрол, шинжлэх ухааны салбарт **нийт 426 төсөл арга хэмжээний 2020 онд санхүүжих 323,45 тэрбум төгрөг**, үүнээс шинэ 253 төсөл арга хэмжээний 122,26 тэрбум төгрөг, шилжих 173 төсөл арга хэмжээний 201,2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт батлагдсан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд боловсролын 423, шинжлэх ухааны 3 төсөл, арга хэмжээ хэрэгжиж байна. Үүнд:

- 128 сургуульд 152,7 тэрбум,
- 111 цэцэрлэгт 60,1 тэрбум,
- 41 дотуур байранд 29,9 тэрбум,
- 15 спорт зааланд 5,0 тэрбум
- 99 их засварын ажилд 33,02 тэрбум,
- 24 төслийн тоног төхөөрөмж 32,33 тэрбум
- 3 шинжлэх ухааны салбарт 5,28 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээ хэрэгжүүлсэн байна.

2020 онд боловсрол, шинжлэх ухааны салбарт хэрэгжих нийт төсөл арга хэмжээ:

Төсөл арга хэмжээ	Хөрөнгө оруулалт	Засвар, тоног төхөөрөмж	Нийт
Шинэ	131	122	253
Шилжих	172	1	173
2019 оны дуусаагүй	139	10	149
<b>Дүн</b>	<b>575</b>	<b>188</b>	<b>763</b>

## 2. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

БСШУС-ын салбарт 2020 онд шинээр 381 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд худалдан авах ажиллагааг дараах байдлаар эрхийг шилжүүлэн ажилласан. Үүнд:

- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яаманд 16,3 тэрбум төгрөг бүхий 5 төсөл арга хэмжээ
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 184 тэрбум төгрөг бүхий 102 төсөл, арга хэмжээ,
- Нийслэлийн Засаг даргад 128,3 тэрбум төгрөг бүхий 49 төсөл арга хэмжээ,
- Аймаг, орон нутагт 272,3 тэрбум төгрөг бүхий 226 төсөл арга хэмжээний эрх шилжүүлэн худалдан авах ажиллагаа зохион байгуулагдсан.

Худалдан авах ажиллагааны явц Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яаманд 100%, Нийслэлийн Засаг даргад эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээ 92.7%, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 96%, аймгуудад эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээ 97,5%-тай зарлагдсан байна. Нийт 382 төсөл, арга хэмжээнээс 378 зарлаж, 365 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч шалгараад байна.

### 3. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ, САНХҮҮЖИЛТ

2020 онд 31 сургууль, 63 цэцэрлэг, 22 дотуур байр, 12 сургуулийн спорт заал тус тус ашиглалтад оруулснаар сургуулийн хүүхэд хүлээн авах хүчин чадал нэг ээлжиндээ 17790 (2 ээлжиндээ 35580) суудлаар, цэцэрлэгийн хүчин чадал 10020 хүүхдийн орны тоогоор, 22 дотуур байр 1320 орны тоогоор тус тус нэмэгдэж, 142 барилга байгууламжид их засвар хийж 270 объектыг улсын комисс хүлээн аваад байна.

Нэр	Улсын хэмжээнд ашиглалтанд орсон		Нийслэлд		Орон нутагт	
	Тоо	Хүчин чадал	Тоо	Хүчин чадал	Тоо	Хүчин чадал
Сургууль	46	17790	20	10560	26	7230
Цэцэрлэг	76	10020	26	4675	50	5345
Сургуулийн спорт заал	8	320	2	0	6	320
Соёлын төв	23	6070	1	1080	22	4990
Спорт заал, талбай	11	1700	1	0	10	0
Дотуур байр	12	1320	0	0	12	1320
Их засвар	86	0	8	0	78	0
Тоног төхөөрөмж	10	0	4	0	6	0
<b>НИЙТ</b>	<b>272</b>	<b>37220</b>	<b>62</b>	<b>16315</b>	<b>210</b>	<b>19205</b>



#### 4. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНХҮҮЖИЛТИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 2020 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар 261,4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон нь нийт санхүүжилтийн 90,8 %-г эзлэж байна.

Төсөл, арга хэмжээ	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Нийт гүйцэтгэл	Гүйцэтгэл хувь	Үлдэгдэл санхүүжилт
<b>БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД</b>	<b>949,521,500.0</b>	<b>323,449,181.5</b>	<b>261,433,472.6</b>	<b>80.8%</b>	<b>62,015,708.9</b>
<b>Боловсрол</b>	<b>803,462,500.0</b>	<b>274,790,181.5</b>	<b>225,169,852.2</b>	<b>81.9%</b>	<b>49,620,329.3</b>
<b>I. Барилга байгууламж</b>	<b>775,306,900.0</b>	<b>252,808,681.5</b>	<b>204,544,132.5</b>	<b>80.9%</b>	<b>48,264,549.0</b>
<i>Шилжих</i>	<i>513,042,400.0</i>	<i>198,105,881.5</i>	<i>157,714,145.8</i>		<i>40,391,735.7</i>
<i>Шинэ</i>	<i>262,264,500.0</i>	<i>54,702,800.0</i>	<i>46,829,986.7</i>		<i>7,872,813.3</i>
<b>II. Их засвар</b>	<b>24,339,600.0</b>	<b>19,611,500.0</b>	<b>18,446,366.6</b>	<b>94.1%</b>	<b>1,165,133.4</b>
<i>Шинэ</i>	<i>24,339,600.0</i>	<i>19,611,500.0</i>	<i>18,446,366.6</i>		<i>1,165,133.4</i>
<b>III. Тоног төхөөрөмж</b>	<b>3,816,000.0</b>	<b>2,370,000.0</b>	<b>2,179,353.2</b>	<b>92.0%</b>	<b>190,646.8</b>
<i>Шинэ</i>	<i>3,816,000.0</i>	<i>2,370,000.0</i>	<i>2,179,353.2</i>		<i>190,646.8</i>
<b>Шинжлэх ухаан</b>	<b>101,786,000.0</b>	<b>5,286,000.0</b>	<b>1,998,741.6</b>	<b>37.8%</b>	<b>3,287,258.4</b>
<b>I. Барилга байгууламж</b>	<b>101,786,000.0</b>	<b>5,286,000.0</b>	<b>1,998,741.6</b>		<b>3,287,258.4</b>
<i>Шилжих</i>	<i>7,786,000.0</i>	<i>2,286,000.0</i>	<i>1,998,741.6</i>		<i>287,258.4</i>
<i>Шинэ</i>	<i>94,000,000.0</i>	<i>3,000,000.0</i>	-		<i>3,000,000.0</i>
<b>II. Их засвар</b>	<b>14,315,000.0</b>	<b>13,415,000.0</b>	<b>5,725,528.8</b>	<b>42.7%</b>	<b>7,689,471.2</b>
<i>Шилжих</i>	<i>1,500,000.0</i>	<i>800,000.0</i>	<i>770,847.4</i>		<i>29,152.6</i>
<i>Шинэ</i>	<i>12,815,000.0</i>	<i>12,615,000.0</i>	<i>4,954,681.4</i>		<i>7,660,318.6</i>
<b>III. Тоног төхөөрөмж</b>	<b>29,958,000.0</b>	<b>29,958,000.0</b>	<b>28,539,350.0</b>	<b>95.3%</b>	<b>1,418,650.0</b>
<i>Шинэ</i>	<i>29,958,000.0</i>	<i>29,958,000.0</i>	<i>28,539,350.0</i>		<i>1,418,650.0</i>

**БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ**